



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 18/01

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэхь заалт, Компанийн
дүрмийн 7 дугаар зүйлийн 7.11.9 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн
Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын
Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн 2017 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаар сайн гэж дүгнэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн
дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 18/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны
зардлын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг хавсралтын дагуу нийт 101,000,000.00 /Нэг зуун нэг сая/ төгрөгөөр баталсугай.


2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо /Д.Дэлгэрмаа/-нд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны
өдрийн 1702 дугаар тогтоолын хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2018 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Зардлын дүн /төг/
1	Үндсэн цалин	79,800.00
2	НДШ	9,200.00
3	Бичиг хэрэг, хангамжийн зардал	1,000.00
4	Шатахуун	1,000.00
5	Томилолт, үйл ажиллагааны зардал	10,000.00
	НИЙТ	101,000.00



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 18/03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дах хэсэгт дараах нэмэлт оруулсугай.
 - 2.2.7. Даатгалын зуучлалын үйлчилгээ
 - 2.2.8. Гаалийн зуучлалын үйлчилгээ
 - 2.2.9. Авто замаар ачаа тээвэрлэх
2. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлд дараахь өөрчлөлт оруулсугай.
 - “8.19.5” гэснийг “8.20” гэж
 - “8.19.6” гэснийг “8.21” гэж
 - “8.19.7” гэснийг “8.22” гэж
3. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хуулийн хугацаанд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Анхбаатар/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



ЧИНЗОРИГ



**“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 18/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, “Монгол шуудан” хувьцаат компанийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

2. “Монгол шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурьдсан нэр дэвшигчдийг тус тус 2 жилийн хугацаатайгаар сонгосугай.

2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

2.1.1 Даваахүү овогтой Нарангэрэл

2.1.2 Даваасамба овогтой Дэлгэрмаа

2.1.3 Чойжилжав овогтой Эрдэнэчимэг

2.1.4 Сайнбаяр овогтой Мөнгөнцэцэг

2.1.5 Чулуун овогтой Ганхуяг

2.1.6 Одончимэд овогтой Одбаяр

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

2.2.1 Батбаяр овогтой Амарсанаа

2.2.2 Мягмаржав овогтой Халиунбат

2.2.3 Дарамбазар овогтой Балдорж

ХУРЛЫН ДАРГА



ЧИНЗОРИГ